

ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

*Авлигын хөрөнгийг хурааж, хүүхэд, залуучуудын хөгжлийн санд төвлөрүүлж
зарцуулах тухай анхдагч хуулийн
төслийн талаар*

2026-08-12

Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “Ардчилсан ёс, шударга ёс, эрх чөлөө, тэгш байдал, үндэсний эв нэгдлийг хангах, хуулийг дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн.” гэж хуульчлан төрийн үйл ажиллагааны нийтээр дагаж мөрдөх суурь зарчим болон авлигаас ангид байх төрийн бодлогын эрх зүйн үндсийг тодорхойлж, түүнчлэн Арван зургадугаар зүйлийн 3 дахь хэсэгт “иргэн нь хөдлөх, үл хөдлөх хөрөнгө шударгаар олж авах, эзэмших, өмчлөх, өв залгамжлуулах эрхтэй.” гэж хуульчлан иргэн өмчийн эрхээ шударгаар хэрэгжүүлэх суурь зарчмыг тунхаглан баталгаажуулсан байна.

Монгол Улс Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий Ассамблейн 2003 оны 10 дугаар сарын 31-ний өдрийн 58/4 дүгээр тогтоолоор баталсан Авлигын эсрэг Нэгдсэн Үндэстний Байгууллагын конвенцыг 2005 оны 10 дугаар сарын 27-ны өдөр соёрхон баталсан. Конвенцын 20 дугаар зүйлд “Хууль бусаар баяжих санаатай үйлдлийг, өөрөөр хэлбэл, төрийн албан тушаалтан хөрөнгө нь их хэмжээгээр нэмэгдсэнийг өөрийнхөө хууль ёсны орлоготой холбогдуулан үндэслэлтэйгээр тайлбарлаж чадахгүй байгаа бол ийнхүү хөрөнгө нь нэмэгдсэнийг гэмт хэрэг гэж тогтооход шаардлагатай байж болох хууль тогтоох болон бусад арга хэмжээг авах асуудлыг оролцогч улс бүр үндсэн хууль болон эрх зүйн тогтолцооныхоо тулгуур зарчимд нийцүүлэн авч үзнэ.” гэж заасан бөгөөд мөн конвенцын 31 дүгээр зүйл нь гэмт хэргийн орлого, түүнтэй адилтгах үнэ бүхий хөрөнгө, орлогыг илрүүлэх, царцаах, битүүмжлэх, хураах арга хэмжээг, 54 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн (с) заалт нь гэмт этгээд нас барсан, оргон зайлсан, эзгүй байгаа болон эрүүгийн журмаар яллах боломжгүй бусад тохиромжтой тохиолдолд ял шийтгэлээс үл хамааран хөрөнгө хураах боломжийг авч үзэхийг, 57 дугаар зүйл нь хураасан хөрөнгийг буцаах, захиран зарцуулахтай холбоотой харилцааг тус тус зохицуулсан. Конвенцын удиртгалд эдгээр зохицуулалтыг хэрэгжүүлэхдээ эрүүгийн, иргэний болон захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны үндсэн зарчим, процессын баталгааг чанд хангах шаардлагыг онцлон тэмдэглэсэн билээ.

Авлигын эсрэг хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.7, 7.1.8-д албан тушаалтан албан тушаалын байдлаа ашиглан эд хөрөнгө олж авах, давуу эрх эдлэх, үндэслэлгүйгээр хөрөнгөжихийг хориглосон бөгөөд мөн зүйлийн тайлбарт “Албан тушаалтан зургаан сарын албан тушаалын цалин хөлс, орлогоос илүү хөрөнгө, орлогыг хууль ёсны дагуу олсон болохыгоо үндэслэлтэй тайлбарлаж чадахгүй тохиолдолд үндэслэлгүйгээр хөрөнгөжих гэж үзнэ.” гэж тодорхойлсон байдаг.

Мөн тус хуулийн 33 дугаар зүйлийн 33.2 дахь хэсэгт шүүгч энэ хуулийн 7.1.7, 7.1.8-д заасныг зөрчсөн этгээдийн тухайн олсон эд хөрөнгө, орлогыг хураах буюу давуу эрхийг хүчингүй болгохоор заасан.

Гэвч Авлигын эсрэг хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.7, 7.1.8 дахь заалт, 33 дугаар зүйлийн 33.2 дахь хэсгийг хэрэгжүүлэх процессын хууль байхгүй байна. Тухайлбал, Авлигын эсрэг хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.8-д заасан “хөрөнгө, орлогыг хууль ёсны дагуу олсон болохыгоо үндэслэлтэй тайлбарлаж чадахгүй” гэдгийг хууль хэрэглээний хувьд хэрхэн ойлгох нь тодорхой бус буюу тус ойлголтод хууль бус гарал, эх

үүсвэртэй хөрөнгө хамаарах эсэх нь тодорхой бус байна. Үүнээс гадна тус хуулийн 7.1.7, 7.1.8-д заасныг зөрчснийг шалгах, тогтоох, хууль ёсны орлогоос давсан хөрөнгийг илрүүлэх, шалгах ажиллагаа, үндэслэл, журам, уг ажиллагааг хэрэгжүүлэх эрх бүхий субъект, хураах санал шүүхэд хүргүүлэх субъект, журам, шүүхийн харьяалал болон шүүхээс хянан шийдвэрлэх журам, нотолгооны стандарт, талуудын нотлох үүргийн хуваарилалт, хөрөнгийн бүрэн бүтэн байдал, үнэ цэнийг түр хамгаалах арга хэмжээ, шударга эзэмшигч, гуравдагч этгээдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлын хамгаалалт, баталгааг хангах зэрэг бусад шаардлагатай асуудлыг зохицуулсан эрх зүйн орчин бүрдээгүй байна.

Албан тушаалтны хувьд хууль бус хөрөнгө нь гэмт хэрэг, зөрчил, авлигын зөрчил болон бусад хуульд заасан хориглолт, хязгаарлалтыг зөрчсөний улмаас бий болохоор байна.

Гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, орлогыг хураах асуудлыг Эрүүгийн хууль болон Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулиар зохицуулж байгаа хэдий ч хэрэгжилтийн хувьд хангалтгүй байгааг авлигын гэмт хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны тоон мэдээллээс харж болно.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явуулж болохгүй үндэслэл бий болсон тохиолдолд гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, орлогыг хурааж авалгүйгээр хэрэг бүртгэлтийг хаах, хэргийг хэрэгсэхгүй болгох, шүүхээс хэргийг шийдвэрлэхдээ гэм буруутайг тогтоож ял оноосон хэдий ч гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, орлогыг хураагаагүй тохиолдол гарч байна.

Иймд гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө орлогыг Эрүүгийн хууль тогтоомжийн механизмаар хураагаагүй тохиолдолд хураагдаагүй тус хууль бус хөрөнгийг хурааж улсын орлого болгох механизмыг бий болгож хэрэгжүүлэх шаардлагатай байна.

Үүний нэгэн адил нийтийн албан тушаалтны **зөрчил үйлдэж олсон хөрөнгө, орлого** нь Зөрчлийн хууль тогтоомжийн механизмаар хураагдаагүй тохиолдолд тухайн зөрчил үйлдэж олсон хөрөнгө, орлогыг хурааж улсын орлого болгох механизм бий болгож хэрэгжүүлэх шаардлагатай байна.

Түүнчлэн, Авлигын эсрэг хуульд заасан **авлигын зөрчил үйлдэж олсон хөрөнгө орлогыг** хураах, хууль бус давуу байдлыг хүчингүй болгох зохицуулалтын процессын тодорхой зохицуулалт байхгүйгээс Авлигын эсрэг хуулийн 7 дугаар зүйл, 33 дугаар зүйл хэрэгжих боломжгүй нөхцөл байдалд байна.

Хууль бус өрөнгө хураах нь зөвхөн эрүүгийн механизмын ойлголт биш бөгөөд зөрчил үйлдэж олсон хөрөнгө, орлогыг хураах асуудал Зөрчлийн тухай хууль тогтоомжоор, мөн авлигын зөрчил буюу Авлигын эсрэг хуульд заасан хориглосон үйлдлийг үйлдэж олсон хөрөнгө, орлого болон нийтийн албан тушаалтны үндэслэлгүй хөрөнгөжсөн 100 сая хүртэл төгрөгний хөрөнгийг хураах асуудал Авлигын эсрэг хуульд тусгагдсан.

Гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгийг Эрүүгийн хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулиар, зөрчил үйлдэж олсон хөрөнгө, орлогыг Зөрчлийн тухай хууль, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулиудаар зохицуулж байгаа бол Авлигын эсрэг хуульд заасан хориглолтыг зөрчсөний улмаас олсон хөрөнгө, орлогыг хураах механизм нарийн тодорхой хуульчлагдаагүй байна.

Иймд Авлигын хөрөнгийг хурааж, хүүхэд, залуучуудын хөгжлийн санд төвлөрүүлж зарцуулах тухай анхдагч хуулийн төслийг албан тушаалтан гэмт хэрэг, зөрчил үйлдэж олсон хөрөнгө орлогыг Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа болон Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааны хүрээнд хураалгүйгээр гэмт хэрэг, зөрчлийг нь эцэслэн шийдвэрлэсэн тохиолдолд үйлчлэхээр, түүнчлэн Авлигын эсрэг хуульд заасан авлигын зөрчил үйлдэж, нийтийн албан тушаалтан гадаад улсад мөрийтэй тоглож олсон хөрөнгө, орлогыг хураахад үйлчлэхээр хуулийн үйлчлэх хүрээг тодорхойлж хуулийн төслийг боловсруулаад байна.

Шийдвэрлэх шүүхийн тухайд одоо хэрэгжиж байгаа практик дээр тулгуурлан иргэний шүүх байхаар төсөлд тусгаад байна.

Мөн шүүхийн шийдвэрийн дагуу хураасан хууль бус хөрөнгийг Хүүхэд, залуучуудын хөгжлийг дэмжих санд төвлөрүүлж зарцуулахтай холбоотой зохицуулалтыг анхдагч хуулийн төсөлд тусган боловсрууллаа.

Эрүү, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай, Авлигын эсрэг хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай болон холбогдох бусад хуулийн төслүүд буюу нийт 17 дагалдах хуулийн төслийг боловсрууллаа.

Тус хуулийн төсөл боловсруулах үүрэг бүхий Ажлын хэсгийг холбогдох байгууллагын төлөөллийг оролцуулан Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2026 оны 7 дугаар сарын 30-ны өдрийн А/129 дугаар тушаалаар байгуулан ажиллаж, холбогдох хуулийн төслийг боловсрууллаа.

Ажлын хэсэг хуулийн төслийг боловсруулах явцад Хууль зүйн үндэсний хүрээлэнгээс хийсэн Авлигын эсрэг хууль тогтоомжид хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ болон зарим шаардлагатай судалгааг, мөн харьцуулсан судалгааг ашиглалаа.

Түүнчлэн Авлигын эсрэг хууль тогтоомжийг хэрэгжүүлэгч гол байгууллагууд буюу Авлигатай тэмцэх газар, шүүх, прокурор, цагдаагийн байгууллага, төрийн аудитын байгууллагаас холбогдох мэдээллийг авч, хэрэгжүүлэгч байгууллагын төлөөлөлтэй хуулийн төсөл боловсруулах явцад уулзалт, ярилцлага хийх байдлаар асуудлыг тодруулан ажилласан.

Хуулийн төслийг олон нийтээссанал авахаар Хууль тогтоомжийн тухай хуулийн 38.2-т заасны дагуу тус яамны албан ёсны цахим хуудсанд 2026 оны 8 дугаар сарын 12-ны өдөр байршуулсан бөгөөд legalinfo.mn сайтад байршуулах арга хэмжээг мөн авч байна.

---o0o---